

**МОНГОЛ УРАН ЗОХИОЛ ДАХЬ СЕНТИМЕНТАЛЬ
ХЭВ ШИНЖИЙН ТУХАЙ**
(*Ц.Дамдинсүрэнгийн “Толь Гэндэн” найраглалын жишээ дээр*)

Д.Галбаатар *

Монголын эрт эдүгээгийн уран зохиол нь өөрийн үндэсний өвөрмөц онцлогтой болох, монголын гэж ялгарах ур хийц, сэтгэлгээ, уран дүр, дүрслэгдэхүүнтэй гэдэгтэй мэтгэлцэх аргагүйтэй адил монголын эрт, эдүгээгийн уран зохиол нь хүн төрөлтний нийт уран зохиол /янз бүрийн үндэстнүүд/-ыг бүрдүүлэгч онцгой хэсэг, ур зүй, уран сайхны сэтгэлгээ, эрэл олз, үр дүнгийн хувьд тусгай ангид бус гэдгийг ямагт санах ёстой зүйл юм. Уран зохиолыг дэлхий дахин, үндэстэн бүр нэг л утгаар ойлгож, тэгэхдээ үндэстнүүд өөрийн уран зохиолынхоо өв, үзэл санаа, урлал зүйн онцлогийг ерөнхий ба тусгайн харьцаанд судлах зайлшгүй шаардлага гарч ирдэг. Дэлхийн урлаг, утга зохиолд гарсан томоохон чиглэл урсгалууд нийт үндэстнүүдийн уран зохиолд нийгэм түүхийн тодорхой нэг шатнаа зайлшгүй давтагддаг ерөнхий хууль зүй байдаг бололтой юм. Ялангуяа тухайн үндэстний хөгжил нь хэдийгээр өөр өөр цаг үе, үе шатнаа оршдог ч хөгжлийн жамаар, нийгмийн хөгжлийн тодорхой нэг үе шатанд аж төрөх ёс, оюуны соёл, нийгмийн хөгжлийн ижил хэв маяг, үндэсний ахуй амьдрал, сэтгэлгээнд гарсан өөрчлөлттэй уялдаж үндэсний урлагийн өвөрмөц төрөл хэлбэрүүд хөгжих, тухайн үеийн онцлогийг тусгахад тохиромжтой нийтлэг арга цаг хугацаа, иргэншил, соёлын хөгжлийн хэр хэмжээтэй уялдаж, урлахуй арга, сэтгэлгээнд томоохон өөрчлөлт гарч, ёс суртахуун зэрэг олон талаараа ялгардаг ч уран зохиол-урлаг болох, хүмүүст хүрэх, өөрсдийн амьдралыг танин ойлгохуйн хувьд нэг зорилгот үйл билээ.

Дэлхийн уран зохиолын хөгжлийн явцад тохиолдсон нийгэм түүхийн өөрчлөлт, цаг үе, нийгмийн байдал, хөгжил, дэвшлийн, өөрчлөлт шинэчлэлийн хэр хэмжээ, сэтгэлгээний дэвшил нь уран зохиолыг ямагт өөрчлөн хувиргаж тухайн цаг үеийнхээ нөлөө хамаарал руу ямагт татан оруулж, дүр дүрслэл, сэтгэлгээ, туурвил зүйд шинэтгэлүүд хийж байдаг түгээмэл зүй тогтолтой. Манай уран зохиол судлалд байдаг нэг нэг түвэгтэй асуудал бол монголын уран зохиолыг зөвхөн өөрдийнх нь хуримтлуулсан /бий болгосон/ тэрхүү сан хөмрөгөөр хязгаарлан тэр хүрээнд дан цэврээр судлах, зөвхөн монголын гэх онцлогийг сайшаах хандлага давамгайлж ирсэн нь өнөөгийн даяаршиж буй дэлхий ертөнцөд хийгдэж буй оюуны соёлын судалгаанаас

* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн Утга зохиолын тэнхим

өөрийн ард түмний бий болгосон үнэт зүйлсийг “илүү эрхэм дээд”-д тооцоод, бусдын үзэл онол, бүтээл туурвилыг хэт “хүнийчлэх”, “харьчлах” хандлага социализмын он жилүүдэд нэлээд гүнзгий хэвшсэн билээ. /Хажиг Мухан. Би нохойн барлдаан байсан ч барилдана, М.Цэдэндорж “Хэрэгтэй бол нохойн амнаас ч үг сонсож бай гэж эмээ минь хэлдэгсэн зэргээр энэ асуудлыг хөндөж байв/

Эл өгүүлэлд дэлхий нийтээр сентиментализм хэмээн нийтээр хэрэглэдэг “харь” үгээр илэрхийлэгдэж хэвшсэн уран зохиолын нэг арга найруулга, чиг хандлагыг монгол уран зохиолын зарим нэг баримт дээр, тэхдээ монголчууд бид ч өөрийн сентименталь сэтгэлгээ, ур зүйн хэв шинж бүхий арга барилыг эртнээс инагш нээн олж, зохиол бүтээлийн зохих өв санг түүхийн урт удаан хугацаанд бүрдүүлэн, улмаар хадгалан тээсээр иржээ. Бид социализмын он жилүүд болон түүнээс өмнөх үеүүдэд ч уран бүтээлийн арга, сэтгэлгээний янз бүрийн хэлбэршил, ур зүйн эрэл, туршилтууд, тэдгээрийн хэв шинжийг тодорхойлох, хувьслын асуудлыг төдийлөн судлаж байсангүй нь өдгөөгийн дэлхийн уран зохиолд дэлгэрсэн янз бүрийн урсгал, чиглэлүүдийг улс төрийн учир шалтгаантай болгож, зөвхөн “өрнөдчилөн” ойлгож, социалист реализмын эсрэг /явч эртний энэ арга найруулгууд ХХ зууны эхэн хагаст буй болсон соцреализмын онол арга зүйн эсрэг байх логик үндэслэлгүй юм. Д.Г/ арга, монгол туурвил зүйд энэ мэт арга найруулга, эрэл туршилт байгаагүй мэт тайлбарлах нь ихээхэн эргэлзээ төрүүлдэг юм. Дэлхий дахинаа ХIХ-ХХ эхэн хүртэл нэг үе хүчтэй дэлгэрсэн энэ томоохон арга найруулга, сэтгэлгээний хэв маягийн үүх түүхийн улбаа мөр, бүтээл туурвилын өв монгол уран зохиолд элбэг юм. Ялангуяа ардын дуу түүний дотор нийгмийн дарлал, нийгмийн ангиудын харилцаа, ялгарал, иргэний ёс суртахуун, аж амьдралаас үүдсэн сэтгэл зүйн өөрчлөлт шилжилтүүдийг гүн гүнзгий тусгасан үгийн урлагийн нэгэн өвөрмөц салаа мөчир бий болсон нь баатрын уян, эвдрээгүй гэнэн хонгор сэтгэл, нийгмийн тэгш бус харилцаа хоёрын хоорондын зөрчлийг уянгын хэлбэрээр илэрхийлдэг, бие даасан онцлог бүхий өвөрмөц арга зүйг бий болгосон нь сентименталь сэтгэлгээний хэв маягтай илүү уялддаг. Ардын аман зохиолд “Өнчин цагаан ботго”, “Ботгоноос нь салгаж жинд хөлсөлсөн ингэний хэлсэн нь”, “Шалзат багахан шарга”, “Хүрэн жороо”... зэрэг хүний зовлон шаналал, нийгмийн тэгш бус харилцаанаас үүдэлтэй гуниглангуйн аяс, бядан явахуй өгүүлэмжтэй сентименталь дууны баялаг өвийг эртнээс бий болгожээ.

Сентименталь зохиолын онцлох гол шинжүүдэд баатрын уян сэтгэл /зам мөрөө олохгүй будилсан аяллын үеийн сэтгэл алдрал, байр сууриа олох эрэл зам зуурт өрнөх үйлийн хослол дээр илрэх хүмүүний хүсэл мөрөөдөл, сэтгэл зүйн хувьсал, сайн сайхныг эрэх, өөрийн орон зайг олохын төлөөх эрэл ба түүний гүнд оршин буй нийгмийн чанартай, ээдрээт асуудлуудыг хөндөж нээхэд оршдог. Сентименталь зохиол нь нэг талаас гуниглангуйн аяс, нөгөө талаас тэр бүр санаагаар эс болох амьдралын адармаа, сайн сайхны төлөөх цуцашгүй тэмцэл, бадрангүй тэмүүллийг хослуулсан дүрийн сэтгэл зүйг шинжлэх, баатруудын үйл, үйлдэхүүний зөрчлөөр хүн- нийгмийн томоохон зөрчил, ирээдүйн сайхныг хүсэн мөрөөдөх сэтгэл зүтгэл хоёрын гүн гүнзгий зөрчил дээр нийгэм ба хувь хүний хоорондын зөрчил мөргөлдөөний үндсийг сэтгэл зүйчлэл, уран сайхны аргаар шинжилдэг арга юм.

Сентименталь хэв шинжийн зохиолын баатрууд нь голдуу шинэ нийгэм ахуйд хөлөө олж чадахгүй, амьдрал, ирээдүйг өөдрөгөөр харж, шинэ орчин ахуйд бядан аялах замдаа сэтгэл зүйн хувьд өөрийн байр суурийг олох зоримог алхмуудыг хийх боловч хуучин ахуй суртахуунаас улирсан элдэв саад бэрхшээлтэй тулгарч, түүнийг даван

туулахыг эрмэлзэх ч хүссэн үр дүнгээ бүрэн олж чадалгүй хувь заяаны төөргөөр санамсаргүй сонголт хийдэг баатрууд байдаг. Ер нь сентиментализм нийгмийн шилжилт, ялангуяа хамжлагат ёс /феодалын эрхт ёс/-ноос хөрөнгөтөн /мөн социалист гм/ нийгмийн нөхцөл байдал, шинэ орон зай руу шилжих шилжилтийн үед хувь хүмүүсийн амьдралд байр суурь олохын төлөөх тэмцэл, тохиолдох бэрхшээл саад, хувь төөргийн ээдрээт замаар баатраа хөтлөн, үндсэн санаагаа ёгт далдлагдмал, наргиантай хурц өгүүлэмж, онцгой маягийн “романтик” сэтгэлтэй баатар, ур зүйн шинэ сэдэл бүхий уран зохиол, урлаг, театрын бие даасан чиглэл хөгжжээ. Өөрөөр хэлбэл шинэ хуучин нийгмийн халаа солио дунд хувь хүний сэтгэл зүйн өөрчлөлт, нийгмийн харилцааны зөрчилт талыг ёгт хошин байдлаар тавьж, сэтгэл зүйн хувирлыг илүү тод харуулдаг уран сайхны арга боловсорчээ. Нэг талаас нийгмийн дарлал мөлжлөг, нөгөө талаас хөгжлийн явцад гарч буй томоохон өөрчлөлтүүдийн нөлөө ард иргэний сэтгэл зүйд хэрхэн нөлөөлж, тэдний оюун санаанд оршин буй эмзэглэл, сэтгэл алдрал амьдралын сонголтыг аян замд гарсан баатрын бэдрэлийн замд уран сайхны аргаар нээж, чинхүү хүсэл мөрөөдлийг нь нийгмийн дотоод учир шалтгаантай нөхцөлдүүлж нээхэд европ дахины сентименталь уран зохиол голлон анхаарч байв.

“Толь Гэндэн” хошин найраглал нь монголын нийгэмд буй болсон хувьсгалт өөрчлөлтийн үеийн ядуу доод анги бүлгүүдийн нийтлэгийг өөрт хадгалсан, аль ч ангид үл хамаарах түргэн “хувиралт”-тай нэгэн өвөрмөц, наргиантай дүр бүтээсэн нь “Толь Гэндэн” юм. Үүний “толь” хэмээх тодотгол бол хувьсгалын дараагаар нийгмийн дотор аяндаа бий болсон иргэний шинэ сонголтууд нь хувь хүний хуучин амьдралын хэвшлийг урвуулан хөрвүүлж, хэтийн зам мөр, учир зүй, зүг чигээ олох шаардлагыг тулгасан тухайн цаг үе, нийгмийн түүхэн нөхцөл байдлын уран тодотгол бөгөөд энэ түүхэн цаг үеийн төвд гол баатар Гэндэнд тавьж, түүний гэнэн хонгор зан төрх, амьдрахуйн төлөөх шургуу тэмцэл, наргиантай адал явдал дүүрэн аяллаар 1930-аад оны эхэн үеийн монголын нийгмийн нөхцөл байдал, монгол хүний амьдралын хэв маяг, зан төрхийн нийтлэгийг тод тусгажээ. Гэндэн бол шинэ нийгэмтэй дасан зохицох, амьдрах орон зай, аятай тохитой аж төрөх, нийгэмд эзлэх байр сууриа олохын төлөө тэмцэгч баатар юм.

1920-1930-аад онд хуулбарлах, хийсвэрлэх, бэлгэдэх, хэлбэрдэх, далд утгын янз бүрийн арга найруулгууд үзэгдэж асан тухай Ц.Хасбаатар \1\, Д.Цэнд \2\, Ш.Гаадамба \3\, Д.Галбаатар \4\ зэрэг судлаачид ч эрдэм шинжилгээний бүтээлдээ тэмдэглэжээ. Тэдгээрийн аргуудын нэг адил урд өмнө тэр бүр хөндөгдөж байгаагүй сонирхолтой эрэл бүхий сентименталь бүтээлийн нэг жишээ нь “Толь Гэндэн” \толгой Шарав\ хэмээх найраглал юм. Гол баатар нь уян зөөлөн сэтгэл, дэврүүн хүсэл мөрөөдөлд хөтлөгдөж, шинэ сайхан амьдралыг бүтээн босгохоор цуцалтгүй бядан аялж, элдэв үйлийг сэдэн санаачлах боловч тодорхой шалтгаануудын улмаас алдаж гэндсээр \бөх, эргэл мөргөл, панз наймаа хийж хохирол амсан дампуурах, улмаар лүйжинч лам, гэлэн, нярав, донир, шанзав, да лам, гэсгүй... хийгээгүй юмгүй болж тус тус бүтэлгүйтсэн\ эцэстээ элдэв хөнгөн хөвсрөгө, хурдан хуумгай ажил сэдэн бүтэлгүй амьдарч, олз ашгийн хойноос хөөцөлдөөд /дээд хүүхэнд дээлийн торго, дунд хүүхэнд дурдан бүс, адаг хүүхэнд ам даавуу шидэж/ хэсэг зуур бийлэгжүү аашилсан ч тусыг эс олж, эцэс сүүлд нь “гүйлгээ өвчин хүрч” тартагтай тулахын үедээ “Хөдөө гарч, Айл болж, Аж төрье гэж бодоод, цагаан морийг унаад, цасны цоохрыг дагаад шар хүрмийг хөвсөлзүүлээд, шанам малгайг сагсалзуулаад хөдөө гарч” сайн бүсгүйтэй учран хүн ёсны амьдрал гэдэг эд хөрөнгө, алба тушаал, хэргэм зэрэг, олз омог, аз сорьсон алхам бус, харин адармаа

саадыг давж, түших сайн хань, өргөж тойлох үр хүүхэд, байран суурин амьдрал хэрэгтэйг ухаарч буй “Толь Гэндэн”-гийн дүрийн зан төрх, зохиолын өрнөлийн шугам, бүтэц зохиомж нь XIX зууны дунд үес өрнөдийн уран зохиолд өргөн дэлгэрсэн сентименталь \5\ хэв маягийн найраглалтай олон талаараа адил юм.

Зохиолч 1933 онд ердөө ганцхан зохиол бичсэн нь эл найраглал юм. 1930-аад оны эхэн үе бол Монгол улс тусгаар тогтнолоо байлдан олж, хувьсгалт шинэ засаг төр тогтнон, амьдралын хуучин хэвшлүүд эвдэрч, хүмүүс шинэ амьдралд татагдан орсноор “Гэндэн” нар нийгэмд байр сууриа олох, шинэ цаг үе, ёсонд дасах, улмаар аж төрөх эрэлт шаардлага тулгарсантай холбоотой монголын нийгмийн шилжилтийн үеийн эгэл ардын тод томруун хэв шинж “Толь Гэндэн”-гийн дүрээр илэрсэн билээ. Зохиолч энэхүү найраглалаас жилийн дараа буюу 1934 онд “Буурал ижий минь”, “Янаг”, “Усан дагина”, “Ургамлын сайхан нь” утга уянгын 4 шүлэг, дараагийн 4 жил дараалан тус бүр ганц ганц шүлэг “Хоёр настай Ро” \1935\, “Зугаацахаар мордсон нь” \1936\, “А.С.Пушкин” \1937\, “Наалинхай хоёр нүд чинь” \1938\ бичсэн нь шинэ үеийн жаргалтай хүүхэд залуус, шинэ сэхээтэн, хайр дурлал, янаг амрагийн сэдэвтэй шүлгүүд нь улс төр, суртал ухуулга, хувьсгал, нийгмийн шүүмжлэл, сургаал номлолоос ангид цэвэр иргэний бадрангуй сэтгэл, цог золбоо, сэтгэлийн эмзэг мэдрэхүйг шингээсэн шүлгүүд байгаа нь Ц.Дамдинсүрэнгийн уянгын яруу найргийн эхэн үеийн цэвэр тунгалаг, жинхэнэ яруу найргийн ая дан, ур хийцийг хадгалаад зогсохгүй феодалын ёсны байгууллаас нийгэм журмын шинэ үе рүү рүү шилжих шилжилтийн үеийн онцлогтой уялдаж сентименталь хэв шинжүүд уран зохиолд нэлээд тод тусч эхэлжээ. Нийгмийн халагдал солигдлын үеийн хямрал, хүний сэтгэл зүйн эмзэг байдал, өөрчлөлтийг нарийн тусгахад аль ч улс үндэстний уран зохиол, урлагт сентименталь аяс хандлага идэвхждэг зүй тогтолтой. Үүний баримт нь “Толь Гэндэн” юм.

Сентименталь уран зохиол зөвхөн өрнө дахины хэв маяг бус дорно дахин, тэр дундаа Монгол ардын аман зохиол, эртний бичгийн уран зохиол, орчин үеийн уран зохиолд ч элбэг юм. Тэдгээр бүтээлийн талаар судалсан нь олон ч судалгааны арга зүй, тайлал тайлбарууд нь зөвхөн реалист онол арга зүй, үзэл санаанд тулгуурлагдсан судалгаа байснаас шалтгаалан агуулга үзэл санаа талыг илүү анхаарч, харин уран сайхны арга найруулгын хэв шинжийн судалгааг бүрхэг бүдэг болгож байсантай холбоотой юм. Сентиментализм гэж юу вэ?

Сентиментализм (фр. *sentimentalisme*, англ. *sentimentalism*) /5, 8. p1145/ Франц гаралтай үг. Эмзэг мэдрэхүй, уян сэтгэл, гуниглан, дэврүүн мөрөөдөл гэх олон утгат нэр томъёо. ХҮШ зууны дундуур өрнө дахинд феодалын байгууллаас хөрөнгөтний нийгмийн шинэ харилцаанд шилжих түүхэн үед Английн уран зохиолд үүсч, улмаар францын уран зохиолоор дамжин дэлхийн урлаг, уран зохиолд дэлгэрсэн уран зохиолын чиглэл. Сентиментализм феодалын байгууллын харилцааг төдийгүй шинэ хөрөнгөтний харилцааны тэгш, шударга бусыг таньж нэг мөлжлөгийг, нөгөөгөөр сольсонд харамсан, сэтгэл алдарсан жижиг хөрөнгөтний уйтгар, харууслыг голчлон илэрхийлж байсан нь санаанд оромгүй амжилт олж, XX зууны эхэн үеийн символизм, реализм, модернизмын хөгжилд зохих нөлөө, түлхэц үзүүлсэн гэж үздэг. Сентиментализмын онол, үзэл санааны үндэс нь субъектив идеализм /Д.Юм, Дж.Беркли нарын сургаал/-д тулгуурласан бөгөөд, нийгмийн /хамжлагат ёсны/ хүний сэтгэл зүйн нийгмээс шалтгаант гүн гүнзгий хямрал, хувирал /гуниглангуй, итгэл алдрал, харуусал, нийгэмтэй дасан зохицох эрмэлзлэг, сэргэлэн ухаалаг сонголт ба бүтэлгүйтэл, туршилт, эрэл хайгуулаас үүдсэн эмзэг мэдрэмж, баатрын ганцаардал, туйлбарт бус чанар,

нийгмийн халаа солио дээр үүсэх хувь хүний сэтгэл зүйн хямрал, хүсэл зориг, бодот байдлын зөрчил мөргөлдөөний явцад зөв зам мөрөө олохын төлөөх тэмцэл ба романтик тэмүүлэл зэргийг нөхцөлдүүлж бүтээдэг онцгой маягийн арга, найруулга юм.

Ч.Лодойдамба “уншигчийн сэтгэлийг шимшрүүлж, бас хайр бахархал, хүндлэл төрүүлэх чанар нь сентиментализм гэдэг өрөвдүүлэх үзлийн гол чанар мөн” /Ч.Л/ гэжээ. Мэдрэхүйн үүргийг чухалчилж, баатрын хөгжилтэй /бүтэлгүй/ аяллын зам гудаст илрэх сэтгэл зүйн хувиралуудыг шинжлэн гаргахад гол сонирхол нь чиглэдэг онцлогтой. Сентименталистууд, соён гэгээрүүлэгчдийн уламжлалыг гүнзгийрүүлэн үргэлжлүүлэхийн зэрэгцээ эгэл энгийн хүмүүст талархалтай хандаж, язгууртны мөлжлөг, шинэ хөрөнгөтний нийгмийн хүнлэг бус талыг шүүмжлэн цэвэр ёс суртахуун, эрүүл чийрэг бие бялдартай, хөрөнгөтний үйлдвэржсэн том хотын нөлөөнд эвдрээгүй хөдөлмөрчин хүний дүрийг урлаг, уран зохиолд дэвшүүлсэнд гол ач холбогдол оршдог. Энэ нь олны ухамсарт өөрийн хүч чадалд итгэх итгэлийг ихээр сэргээдэг тухай Л.Стерн тэмдэглэсэн нь бий.

Өнгөрсөн зуунд Өрнийн уран зохиолд ардчилал дэлгэрч, уран дүрслэлийг загварчлал, мухардлаас гаргах, урлагийн төрөл зүйлийг шинэчлэн баяжуулах чигт дэвшилтэд алхмуудыг хийсний нэг нь энэ чиглэл юм. С.Ричардсоны “*Памела буюу өргөмжлөгдсөн буянтан*” зохиолоор гараагаа эхэлж, Ж.Ж. Руссо “*Шинэ Элиоза*”-гаар үзэл онол нь төлөвшин, Н.М.Карамзин, Л.Стерн, О.Гольдсмитийн туурвил зүйн туршлагаар төлөвшсөн билээ. “*Шинэ Элиоза*” зохиолын язгуур угсаагүй тайж Сен-Пре нь баяны охин Юлийд дурлаж, тэдний хоорондын харилцаа, уян зөөлөн сэтгэлийг илтгэсэн хайрын захидлаар роман зохиомжлогдож, нийгмийн олон эмзэг сэдэв хөндөгдөх ч гол төвд нь дурлалт хоёрын дундаас гэр бүл, нийгмийн учир шалтгаанаас үүдэлтэй уйтгар, гуниг, шаналал зовлон, уян зөөлөн сэтгэлийн илрэлүүд тод ялгарч, гүн шингэсэн байдаг. Романы үндсэн зөрчил нь баатруудын сэтгэл зүйн дотоод зөрчил, мэдрэмж, оюун санаа, нийгмийн байр суурийн ялгарал хооронд өрнөх бөгөөд эцэстээ ямар нэг соён гэгээрүүлэх зорилгоор төгсдөг. “Толь Гэндэн”-гийн эрэл хайгуул, туулсан зам, эцсийн шийдэл нь үүнтэй адил хэв шинжтэй юм.

Сентименталистууд дотроо үзэл баримтлалын хувьд зөрчилтэй байв. Тэдний гол зорилго нь нийгмийн харилцааны ээдрээг хувь хүний дотоод дахь сэтгэл зүйн мөргөлдөөнийг үзүүлэхээсээ илүү хувь бодгалийн /баатрын/ сэтгэл зүй, зуршмал зан суртахуун, амьдралыг үзэх үзэл, түүнд хандах хандлага, янз бүрийн харилцаанаас үүтгэгдсэн уян сэтгэл, хэнэггүй зан төрх, сэтгэл алдралын чанартай зөрчлүүдийг нээх явдал юм. Ийм чанарыг нь социалист реализмын онолд нийгмийн амьдралыг дүрслэхийн оронд нэг хүний заяа төөрөг, сэтгэл санааны хямралыг мөрдөхөд сонирхол нь чиглэсэн хэмээн шүүмжилж, Л.Стерний “*Итали, францаар хийсэн уян сэтгэлийн аян*”, “*Кларисса Горлоу*” /7/ бүтээлийг хурц шүүмжилж байсан билээ.

Тэд соён гэгээрүүлэгчдийн дэвшүүлсэн “хүний язгуурт хамааралгүй эрхэм чанар”-ын тухай, хувь хүний эрх чөлөөг эрхэмлэх, феодалын нийгмийн харгис хэрцгий атлаа, сул дорой байдал, нийгэмд үүссэн гүн гүнзгий зөрчлийг инээд наргиантайгаар шүүмжилж, гэгээрүүлэх үзэл санааг үргэлжлүүлж “*байгалийг дуурайх*”, энэрэл нигүүслийг өргөмжлөн амьдралын төлөө зүтгэгч чөлөөт иргэнийг дүрслэх талаараа классицизмын хуучин уламжлалд хүндэтгэлтэй хандаж байв. Гэхдээ хувь хүний ганцаардал, бодь сэтгэл бол оюун санааны илэрхийлэл бус мэдрэмж, мэдрэхүйн хэв шинж юм гэсэн зарчмыг барьж, уран зохиолыг шинэ өнгө аяс, дүрээр баяжуулан, чөлөөт сэтгэлгээг өргөмжлөн, уран зохиолын хэлийг баялагжуулах, зохиолч баатрынхаа

сэтгэлийн ертөнцөд нэвтрэх явдалд их холбогдол өгч байснаараа соён гэгээрлийн ба классицизмын үеийн бүтээлүүдээс урагш ахиулжээ. Сентименталь зохиолын агуулгад “дууль”-лаг явдал, уянгын хэв шинжүүд голлоно.

Сентименталь зохиолчид нийгмийн тааламжгүй байдал, мөлжлөг, эгэл хүний хоорондын зөрчлийг гүн нээхдээ, нийгмийг хараан зүхэх бус эгэл хүний сэтгэл санаа, зан суртахууны хувьслаар илэрхийлэх, хүний оюун санаа, хүсэл мөрөөдөл ба бодот байдлыг тусгах бус, хүний сэтгэл мэдрэхүйн ертөнц рүү өнгийж, тэндээс амьдралын үнэнийг хайх байдал, бие хүний хөгжлийг зөвхөн зан суртахууны үүднээс нээхийг эрмэлзэж байснаараа урлагт томоохон шинэтгэл хийсэн юм. Чухам ийм шинж Ц.Дамдинсүрэнгийн “Толь Гэндэн” хошин найраглалд төгс төгөлдөр бүрэлдсэн аж. Тодруулбал уран зохиол дахь сентименталь хэв шинж нь баатрын “...мэдрэмжийг тэжээх, өдөөх...сонгох”-д оршдог үндсэн шалгуурууд Гэндэнд төгс төгөлдөр шингэсэн байна.

Өрнөдөд Т.Грей, К.Юнг, оросын Н.М.Карамзин нарын бодрол, уран сайхны бүтээлд хийсэн шинжилгээнд сентименталь зохиолд “уян зөөлөн, *наалинхай сэтгэл, дэврүүн мөрөөдөл, бядан аялахуй, нийгмийн ахуй байдлыг сэм далдуур шүүмжлэн ёгтлосон аяс, аян замын ганцаардал, паянт явдал, гуниглангуй аяс хандлага*” /6/ хүчтэй шингэснийг онцолсон бөгөөд ийм шинжүүд “Толь Гэндэн”-ийн аяллын бүх хэсэгт нэвтэрхий шингэсэн төдийгүй баатрын -сэтгэл зүйн түргэн шилжилт /Хэнтий ханыг тайхад тоот бөхийн тоонд орж, торгон зодгийн мөрөн дээрээс тов хийтэл атгаж, Хийсгээ мэргэн заан цол олох, эргэл мөргөл хийж эцэс хойтыг бодох, арилжаа наймаа хийж ашиг хонжоо харах...гм/, уярал гунихрал, -бодол гансрал, гаслант амьдралын үүтгэл шалтгааныг тодруулж, гүн ухааны эргэцүүллийг суулгах, -нийгмийн орчин, ахуйгаас үүдсэн сэтгэл зүйн шинжтэй эмзэглэл түлхүү орж ирж байгаа нь уг зохиолыг сентименталь хэв шинжийн зохиол хэмээн үзэх онолын тулгуур үндэслэл болж байна.

Барууны уран зохиол судлалд сентиментализмын талаарх мэдлэг туршлага илүү өргөн хүрээтэй төдийгүй уран бүтээлийн урлахуйн бие даасан арга, чиг хандлага, үзэл санааны цогц ойлголт болж төлөвшсөн билээ. Харин монгол уран зохиолын хөгжил ч цаг хугацааны хувьд хожуу мэт харагдавч өөрийн үндэсний уран зохиолд сентименталь хэв шинж бүхий уран зохиолын санг бий болгосон ч тэрхүү үндэсний өвөрмөц онцлогтойгоор уламжлал туршлагыг өдгөө хүртэл нарийвчлан тогтоогоогүй байна. “Монголын уран зохиолын онол, түүхийн зангилаа асуудлууд” /2001, 2010 хоёрдугаар хэвлэл/ номд монгол хэв шинжийн сентименталь уран зохиолын эрэл хайгуулын талаар оруулж чадаагүй бөгөөд энэ лүгээ бусад арга найруулгын үндэсний уламжлал, монгол хэв маягийг тогтоох явдал нь монголын эртний ба орчин үеийн уран зохиолын хөгжил нь дэлхийн өндөр хөгжсөн улс үндэстний уран сайхны сэтгэлгээнээс сул дорой, эсвэл тийм уран сайхны туршлага байхгүй мэтээр ойлгох нь буруу гэдгийг сануулах зорилготой юм.

Сентиментализм монголчуудад харь холын туршлага, үзэгдэл төдий зүйл биш, нийгэм түүхийн хөгжлийн тодорхой үе шатанд үндэстнүүдийн уран зохиолд янз бүрийн урлахуй арга төлөвшиж, эрчимтэй хөгждөг түгээмэл зүй тогтолтой. Дундад зууны хагацал, гуниг, гэмшил, ганцаардал, мөрөөдөл санагалзлын дуулал зохиолуудын өв санг сайтар нягтлах, аман зохиол, эртний уран зохиолд хуульч Сандаг, Ишсамбуу, Агваанхайдав...нарын бүтээлийг юун түрүүн нарийвчлан судлах шаардлагатай юм. Чухам эдгээр уламжлал дээр Ц.Дамдинсүрэн “Толь Гэндэн” бядан явахуй, нийгэмд байр сууриа олохгүй хөглөж, түүний төлөө эрвийх дэрвийхээрээ тэмцэж яваа гэнэн хонгор

зан төрх бүхий сонирхолтой дүр бүтээжээ. Монгол уран зохиолд ялангуяа ардын дуу, аман туульс, харилцаа дууны төрөл жанруудад сентименталь хэв шинж тод харагддаг.

Ц.Дамдинсүрэн “Толь Гэндэн” /1933/ хэмээх хошин найраглал нь нийгмийн шилжилтийн үеийн ороо бусгаа цагийн туйлаанд ширвэгдэн шидэгдэж, амьдралын алтан жолоонд хүрэх гэж эрвийх дэрвийхээрээ зүтгэж буй “Толь” хэмээх Гэндэнгийн “аятайхан амьдрал” хайсан сонирхолтой аялалын наргиант паян, түүнд шингэсэн хүнлэг, уян зөөлөн сэтгэлийн огцом эргэлтүүд, амьдралын сайн сайхан, гэрэл гэгээ өөд тэмүүлэн унаж тусаж яваа зам бол яах аргагүй шашин суртахуун ноёрхсон, феодалын хязгааргүй ноёрхолд автсан ахуй цагийн төгсгөл, шинэ цаг үе, шинэ нийгмийн халаа солионы торгон заагт тулж ирсэн монгол залуучуудын дүрийн нийтлэг зан төрх бөгөөд цаг үеийн туйлаанд шидэгдэж, олныг санаж сэдэн, түүнийхээ хэрээр ялж, ялагдал хүлээж яваа Гэндэнгийн зан төрх, аяллын нэгээс нөгөө рүү урван орох паян явдал сэлт нь сентименталь хэв шинжийн дүрийн бүтэц мөн. Ц.Дамдинсүрэн гуай уг найраглалын тухайд “Ард олны дунд үе улиран ярьсаар ирсэн домог, явган зугаа мэтийг найруулж “Толь Гэндэн”-г бичсэн” /9/ Энэ нь “эгэл нэг паянт явдлын түүх биш” /10/ болохыг гадаадын эрдэмтэд тэмдэглэжээ.

Цагийн жамаар Гэндэнгийн амьдарч дассан нийгэм задарч, тэр нь хүмүүсийн тогтсон амьдрал, хувь төөрөг, нийгмийн байр суурь, ахуй хэвшлийг эвдэн, зам мөрөө олохгүй яваа монголчуудын сэтгэл зүйн ертөнц, явдал үйлийн зураглал мөн. “Толь” Гэндэн бол монголын орчин цагийн сентименталь уран зохиолын сонгодог дүр төрх юм. Үүнийг судлаачид голдуу нийгмийн шилжилтийн үе болон хошин шог зохиол хэмээн тодорхойлоод, нийгмийн нөхцөл байдал, түүний доторх эгэл иргэний амьдрал, зан төрх хийгээд найруулгын хэв маягийг төдийлөн хөндөж байсангүй.

НОМЗҮЙ

1. Ц.Хасбаатар “Монголын уран зохиолд реализм хөгжсөн нь” УБ 1980
2. Д.Цэнд “Монголын уран зохиол. УБ, 1959
3. Ш.Гаадамба “Уран зохиолын онолын үндэс” УБ 1989
4. Д.Галбаатар “Монголын уран зохиолын онол, түүхийн зангилаа асуудал” УБ 2001
5. Д.Галбаатар “Уран зохиол” /онол, түүх, шүүмжлэл/ нэвтэрхий толь, УБ 2012
6. Г.Н.Поспелов “Теория литературы” М, 1978
7. Модернизм анализ и критика основных направлений. М, 1997
8. the NEW PRINCETON ENCYCLOPEDIA of POETRY and POETICS. Princeton university press. 1993 p
9. Ц.Дамдинсүрэн “Түүвэр зохиол” УБ, 1969. 14-р тал
10. Бэрды Кербабаев. “Искренность, лиризм, изящество” ЛГ 1959 №51

SUMMARY

In this article, the author studies “*Toli Genden*” /Mirror Genden/ by Ts. Damdinsuren. This humorous fiction illustrates the characteristics of the poor and their lifestyles during the social change of Mongolia in 1930s. The keenest insights into social structure its deepest values and tastes have been revealed by the character ‘Genden’.